
VOL. 1 MAY 2026

Justice in life and empire



Contents

HISTORY

Genghis khan

A brief overview of the key dates of the Mongol Empire

The Secret History of the Mongols

Dr. T. Sukhbaatar

Alan Gua, the Wise Forebear of the Mongols
Хүннү гүрний түүх
The justice of Gengis Khan: in Life and Empire
Chagatai Khanate (Uls)
Yuan Dynasty. Kublai Khan
Battles of Khalkhin Gol

CULTURE

Valeria Porokhova. A Lifelong Journey to the Quran
How Ancient Greece influenced Indian strategic thought and statecraft
Dashdorjiin Natsagdorj
Dr. Dimitris Bakolas
Bair Dugarov
Night Thoughts on the Grasslands near Ulaanbaatar. Dr. Song Jia Jun
Mongolian Naadam
Tsagaan Sar

SCIENCE

Greece is the birthplace of great people and the Olympic Games
Ochirin Namnandorj
Archimedes

WORLD

Qatar is a beautiful country
Views from Greece
Ulaanbaatar. Sukhbaatar square
The talented Kalaitzis
Coffee and the magic of India
Gandantegchinlen Monastery
Ibn Sina’s legacy – a scientific treasure that unites times and continents
ШХА-аас дэлхийн сорилтуудад хариу өгч сурлаа

HISTORY · 09 APRIL 2026 · ADMIN

Genghis khan

Ong Khan met Genghis khan in the Black Forest on the Tula River, and there they agreed to call each other father and son.



Ong Khan met Genghis khan in the Black Forest on the Tula River, and there they agreed to call each other father and son. The reason they began calling each other father and son was this: Ong Khan was a sworn brother of Yesugei Baatur, Genghis khan’s father, and therefore he was like a father to Genghis khan. This was the reason they began calling each other father

and son. They uttered the following words: “In war against numerous enemies, we will fight together. In hunts for wild animals, we will hunt together.” Genghis khan and Ong Khan also said to each other: “If, out of envy, the toothed snake of slander incites us against each other, we will not believe the slander. We will believe only when we meet and explain ourselves. If the fanged snake of malice incites us against each other, we will not be angry, but will believe only when we talk with each other.”

When they finished these speeches, they began to live in friendship and harmony.

A brief overview of the key dates of the Mongol Empire

The Great Mongol Empire (1206–1368) was the largest continental state in human history, occupying territory from the Pacific Ocean to the Mediterranean Sea.



The Great Mongol Empire (1206–1368) was the largest continental state in human history, occupying territory from the Pacific Ocean to the Mediterranean Sea.

1. In 1162, the Great Son of the Mongolian People, Temujin (Genghis Khan), was born in the town of Delun-Boldok, on the banks of the Onon River

2. Temujin (the future Genghis Khan) was first proclaimed khan in 1189. At that time, the Mongol nobility elected him ruler of the Taichiud tribe and the Kiyat clan, after which he adopted the title “Genghis”

3. 1202 — Temujin’s destruction of the Tatars

4. 1206 — Temujin proclaimed Genghis Khan and the formation of a unified state on the territory of Mongolia. Genghis Khan carries out his great reforms. The Yasa of Genghis Khan comes into force

5. 1207–1211 — Conquest of Siberia
6. 1209 — The Uyghurs submitted to Genghis Khan
7. 1211-1215 — The Mongol conquest of Northern China
8. 1215 — Capture of Beijing
9. 1213 — The Mongols conquered the provinces of Hebei and Shandong
10. 1218 — The Mongol conquest of East Turkestan and Semirechye
11. 1219 — The beginning of the conquest of Central Asia
12. 1219-1221 — The Mongol conquest of Khorezm, invasion of Azerbaijan
13. 1220, spring — capture of Samarkand
14. 1220 — Genghis Khan founds the future capital of the empire, Karakorum
15. 1223, May 31 — the Mongol defeat of the combined forces of the Polovtsians and Russians at the Kalka River
16. 1224-1227 –Shortly before his death, Genghis Khan divided the conquered Mongol Empire among his four sons. Each son received an ulus (allotment) to govern, but the entire empire remained subordinate to the supreme ruler, the Great Khan. This historical division resulted in the formation of four main uluses:
    Ulus of Jochi: lands west of the Irtysh River, including the steppes of modern-day Kazakhstan, the Volga region, and further west. The Golden Horde later formed on this basis.

    Ulus of Chagatai: included southern and southeastern Kazakhstan (Zhetysu), Central Asia, and Eastern Turkestan.

    Ulus of Ogedei: encompassed the lands of western Mongolia, Altai, Tarbagatai, and the upper reaches of the Irtysh River.

    Ulus of Tolui: the original Mongol lands in Central Asia (Mongolia).
17. 1227 — death of Genghis Khan
18. 1229 — election of Ögedei as the new Khan of Mongolia at the Khuruldai
19. 1235, spring — The Great Kurultai, which summarized the wars with the Jin and Khorezm empires and outlined the directions for further expansion.
20. 1235 — Ogedei proclaims Karakorum the capital of the Mongol Empire and begins

massive construction there.

21. 1236 — The Mongol army approaches the Volga and defeats Volga Bulgaria.
22. 1237–1242 – Mongol invasion of Rus′
23. 1240 – Creation of the “Secret History of the Mongols” by an unknown author
24. 1242 – The Mongols captured Zagreb and reached the shores of the Adriatic Sea
25. 1246 – Proclamation of Guyuk as Khan of Mongolia
26. 1245–1247 – Plano Carpini travels to Karakorum and brings the Pope a letter from the new Great Khan Guyuk, who replaced Ögedei – one of the first attempts to establish an alliance between the Mongols and the Crusaders
27. 1247–49 – Journey of Prince of Rus′ Alexander Nevsky to the Horde to Batu Khan
28. 1252 – Conquest of Iran by the Mongols
29. 1253–1255 — Willem de Rubruck’s journey to the court of the Great Khan Möngke in Karakorum via Soldaya (Sudak) and Batu Khan’s headquarters in Sarai
30. 1256-1260 — Kublai Khan proclaimed Khan of Mongolia.

    Formation of the Hulaguid state as part of the Mongol Empire.

31. 1260, March 1 — The allied army of Mongols, Armenians, and Antioch enters Damascus.
32. 1271 — Kublai Khan conquered most of China and founded the Yuan Dynasty of Chinese emperors
33. 1274–81 — Kublai Khan’s military campaigns against Japan.

    1279 — Completion of the Mongol conquest of all of China. Kublai Khan moves the capital to Khanbaliq (later renamed Beijing).


34. 1294, February 19 — Death of Kublai Khan. End of the era of Mongol conquests.
35. 1368 – The Red Turban Rebellion in China, the overthrow of the Yuan Dynasty.



HISTORY · 09 MAY 2026 · ADMIN

The Secret History of the Mongols

The secret history of the Mongols is the oldest surviving literary and historical work in the Mongolian language. Written by an anonymous author shortly after the death of Genghis Khan. The book is written in a unique blend of prose and epic poetry.



The secret history of the Mongols is the oldest surviving literary and historical work in the Mongolian language. Written by an anonymous author shortly after the death of Genghis Khan. The book is written in a unique blend of prose and epic poetry. It covers the mythical origins of the Mongol people, the dramatic life of Temujin (Genghis Khan) from his difficult childhood to his rise as a world conqueror and concludes with the reigh of his son and successor Ogedei Khan. It provides deep insights into the nomadic culture, shamanistic beliefs, social structures and customary laws of the 13 – th century Mongols. Today " The Secret History of the Mongols" is regarded not only as a crucial historical document for global medieval history but also as a masterpiece of nomadic literature and a symbol of Mongolian national identity.

The Government of Mongolia has promoted "The Secret History of the Mongols" as a treasured national heritage. To preserve and pass on this invaluable historical work, a law and related government policies have encouraged Mongolian families to keep a copy of the book in their homes.
This initiative aims to strengthen national identity, preserve the Mongolian language and culture, and ensure that future generations learn about the history, traditions and values of the

Mongolian people.

“The Secret History of the Mongols” consists of twelve chapters. This book has been translated into many languages. I am pleased to present to you this charming work in the Mongolian language.

Монголын нууц товчоо

Тэмүжиний уг гарал ба бага насны уе

1. Чингис хааны язгуур, дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ-чино, гэргий Гуа-Маралын хамт тэнгис далайг гэтэлж ирээд Онон мөрний эх Бурхан халдун ууланд нутаглаж Батцагаан гэдэг нэгэн хөвүүнийг төрүүлжээ.

2. Батцагааны хөвүүн Тамача, Тамачийн хөвүүн Хоричар мэргэн, Хоричар мэргэний хөвүүн Уужим буурал, Уужим бууралын хөвүүн Саль-хачау, Саль-хачаугийн хөвүүн Ихнүдэн, Ихнүдэний хөвүүн Шинсочи, Шинсочийн хөвүүн Харчу.

3. Харчугийн хөвүүн Боржигидай мэргэн бүлгээ. Боржигидай мэргэний гэргий нь Монголжингуа, түүнээс төрсөн хөвүүн Торголжин баян. Торголжин баян, Борогчин гуа гэргийтэй, Боролдайсуялби гэдэг залуу зарцтай, дайр бор хоёр хүлэг морьтой бүлгээ. Торголжин баяны хөвүүн Дува сохор, Добу мэргэн хоёр бүлгээ.

4. Дува сохор, магнай дундаа ганц нүдтэй гурван нүүдлийн газар харах бүлгээ.

5. Нэгэн өдөр Дува сохор, Добу мэргэн дүүтэйгээ Бурхан халдун уулан дээр гарав. Дува сохор, Бурхан халдун дээрээс харвал Түнхэлэг горхин уруу нэгэн бүлэг иргэн нүүж айсуй.

6. Дува сохор өгүүлрүүн: “Тэр нүүдэл иргэний дотор, тэрэгний мухлагийн өмнө нэг сайхан охин сууж явна. Хүний гэргий болоогүй бол Добу мэргэн дүү чамд гуйж гэргий болгоё” гээд түүнийг үзүүлэхээр Добу мэргэн дүүгээ илгээв.

7. Добу мэргэн, тэр нүүдэлд хүрч охиныг үзвэл үнэхээр алдартай, гоо сайхан охин бөгөөд хүний гэргий болоогүй ажээ. Нэр Алун гуа гэнэ.

8. Энэ охин, хорь түмдийн ноён Хорилардай мэргэний гэргий Баргужин гуагаас хорь түмд (хорь буриад)-ийн нутаг Ариг ус гэдэг газар төржээ. Түүний эх Баргужин гуа бол хол газрын Баргужин төхүмийн эзэн Баргудай мэргэний охин бүлгээ. Тэр бүлэг иргэн бол Хорилардай мэргэнийх ажээ.

9. Хорилардай мэргэн, хорь түмдийн газарт булга, хэрэм зэрэг ан гөрөөс агнахаа хориглон булаалдаж харилцан муудалцаад салж, хорилар овогтон болоод Бурхан халдун ууланд ан гөрөөс элбэг гэж сонсож, Бурхан халдуны эзэн бурхан босгосон Шинч баян урианхайтай уулзахаар нүүж ирсэн ажээ. Энэхүү хорь

түмдийн ноён Хорилардай мэргэний охин, Ариг уснаа төрсөн Алун-гуаг гуйж, Добу мэргэний гэргий болгосон ёс тийм ажээ.

10. Алун-гуа, Добу мэргэнд ирээд Бүгүнүтэй, Бэлгүнүтэй гэдэг нэртэй хоёр хөвүүнийг төрүүлэв.

11. Дува сохор ах нь дөрвөн хөвүүнтэй бүлгээ. Дува сохрыг үхсэний хойно түүний дөрвөн хөвүүн, Добу мэргэнийг авга гэж үзэхгүй доромжилж салж нүүгээд дөрвэд овогтон болов.

12. Түүний хойно нэг өдөр Добу мэргэн Тогоцог өндөр дээр гөрөөлөхөөр гарвал, ой дотор нэгэн урианхай хүн гунжин буга алаад хавирга цоройг шарж байхад уулзаж.

13. “Нөхөр шоролгодоо” гэж Добу мэргэн хэлбэл, тэр хүн уушги зүлд ба арьсыг өөрөө авч, бусдыг цөм Добу мэргэнд өгөв.

14. Добу мэргэн, тэр бугын махыг ачиж явтал замд хүүхдээ хөтөлсөн нэгэн ядуу хүн учрав.

15. “Чи юун хүн бэ?” гэж Добу мэргэн асуувал, тэр хүн өгүүлрүүн: “Би Малиг баяудын хүн. Одоо би ядарч явна. Тэр гөрөөсний махнаас надад өг. Би энэ хөвүүнээ чамд өгье” гэвэл.

16. Добу мэргэн зөвшөөрч, бугын өрөөсөн гуяыг тэр хүнд өгөөд хөвүүнийг авч ирж гэртээ зарцлах болов.

17. Тэгж байтал Добу мэргэн үгүй болов. Добу мэргэнийг үгүй болсны хойно түүний гэргий Алун-гуа бэлбэсэн бөгөөтөл Буха хатаги, Бухату салжи, Бодончар мунхаг гэдэг нэртэй гурван хөвүүнийг төрүүлэв.

18. Урьд Добу мэргэнийг амьд бүхий цагт төрсөн Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр хөвүүн, эх Алун-гуагаас эчнээ хэлэлцсэн нь: “Бидний эх, ойр төрлийн эрэгтэй хүнгүй ба эргүй бөгөөтөл энэ гурван хөвүүнийг төрүүлэв. Гэр дотор ганц Малиг баяуд овгийн зарц хүн байна. Энэ гурван хөвүүн, түүний хүүхэд биз” гэж эхээс далд хэлэлцэхийг нь Алун-гуа мэдээд.

19. Хаврын нэгэн өдөр хонины хатсан мах чанаж Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Буха хатаги, Бухату салжи, Бодончар мунхаг таван хөвүүндээ идүүлээд тэднийг зэрэгцүүлэн суулгаж, хүн бүрд нэжээд мөс (сум буюу нарийн мод)-ийг хугал гэж өгвөл амархан хугачиж орхив. Бас таван мөсийг нийлүүлж баглаад хугал гэж өгвөл тавуулаа дараалан оролдож хугалж чадсангүй.

20. Үүнд Алун-гуа эх нь өгүүлрүүн: “Бэлгүнүтэй, Бүгүнүтэй та хоёр намайг энэ гурван хөвүүнийг яахин төрүүлэв, хэний хөвүүд бол гэж сэжиглэн хэлэлцэнэ. Сэжиглэх

тань зөв.

21. Гэвч, та нар учрыг мэдэхгүй байна. Шөнө бүр цагаан шар хүн, гэрийн өрх тотгоор гийгүүлэн орж ирээд миний хэвлийг илэхэд түүний гэрэл миний хэвэлд шингэх бүлгээ. Тэр хүн, гарах нар сарны хилээр шар нохой мэт шарвалзсаар гарч одно. Дэмий яахин өгүүлнэ та. Түүнээс үзвэл тэнгэрийн хөвүүд биз. Хар тэргүүт хүнтэй адилтгаж яахин болно. Хамгийн хаад болох цагт харц хүн сая учрыг мэднэ" гээд.

22. Бас Алун-гуа, таван хөвүүнээ сургаж өгүүлрүүн: "Та таван хөвүүн, миний нэгэн хэвлээс төрсөн биш үү. Та нар ганц ганцаар салбал нэжээд сум мэт хүнд хялбархан дийлэгдэнэ. Та нар эв эеэ нэгтгэвэл тэр багласан таван сум мэт бэх болж, хэнд ч хялбар дийлэгдэхгүй болно" гэв. Тэгж байтал Алун-гуа эх нь үгүй болов.

23. Эх Алун-гуаг үгүй болсны хойно ах дүү тавуулаа, адуу малаа хуваах болж, Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Буха хатаги, Бухату салжи дөрвүүлээ юмаа хувааж аваад дүү Бодончар мунхагийг бядуу гэж урагт үл тооцож хувь эс өгөв.

24. Бодончар урагт эс тоологдох атал, энд юу хийж сууна гээд гол дайрт, годил сүүлт орог шинхул морио унаж үхвэл ухье, амьдарвал амьдаръя гэж Онон мөрөн уруу зорьж одов. Тэнд Балжийн арал гэдэг газар хүрч өвсөн эмбүүл гэр барьж суув.

25. Тэгж байтал хар хур шувууг бор харцага барьж идэхийг үзэж, гол дайрт, годил сүүлт орог морины хялгасаар урхи хийж, тэр бор харцагыг барьж авчрав.

26. Бодончар, идэх юмгүй тул чонын гууд хорьсон гөрөөсийг мярааж харван алж идэх буюу чонын идсэн сэгийг түүж гэдсээ хооллож, харцагаа тэжээсээр тэр он гарав.

27. Хавар болж, нугас ирэх цагт харцагаа сойж тавиад галуу, нугас олныг алж, идэж үл барах тул,
Мөчир бүрээс
Мөч гуя өлгөж
Хожуул бүрээс
Хоёр гурван
Шувуу өлгөсөн нь ялзрахад хүрчээ.

28. Битүү модот уулын хяраас нэгэн бүлэг иргэн, Түнхэлэг горхин уруу нүүж ирэв. Бодончар, харцагаа тавин өдөр бүр тэр иргэнд очиж цэгээ гуйж уугаад, шөнө өвсөн эмбүүл гэртээ ирж хонох бүлгээ.

29. Тэд иргэн Бодончарын харцагыг гуйвал эс өгөв. Тэд иргэн, Бодончарыг хэн юун хүн бэ гэж асуухгүй, Бодончар бас тэр иргэнийг юун иргэн гэж асуухгүй явна.

30. Гэтэл Буха хатаги ах нь Бодончар мунхаг дүүгээ энэ Одон мөрөн уруу одлоо гэж

нэхэн ирж, Түнхэлэг горхинд нутаглах тэд иргэнд хүрээд тийм морьтой, тийм хүн үзэгдэв үү гэж сурвал.

31. Тэд иргэн өгүүлрүүн: “Өдөр бүр нэгэн хүн манд ирж эсэг (цэгээ) ууж одно. Тэр хүн ба түүний морь, чиний сурдагтай адил байна. Түүнд нэг харцага бий. Тэр, шөнө хаана хонодгийг мэдэхгүй. Баруун хойноос салхи салхилбал түүний харцагаар бариулсан нугас галууны өд сөд нь цас мэт бутарч хийсэж ирнэ. Бодвол түүний гэр холгүй биз. Одоо түүний ирэх цаг болов. Хоромхон хүлц” гэв.

32. Удалгүй Түнхэлэг горхин өөд нэгэн хүн айсуй. Хүрч ирвэл Бодончар мөн. Буха хатаги ах нь таньж аваад Онон мөрөн өөд дагуулан давхив.

33. Бодончар, Буха хатаги ахын хойноос даган хатирч өгүүлрүүн: “Ах аа, ах аа, бие тэргүүтэй, дээл захтай нь сайн” гэвэл, ах нь тэр үгийг хайхарсангүй.

34. Бодончар мөн үгийг хоёрдугаар удаа өгүүлбэл, ах нь хариу хэлсэнгүй. Мөн үгийг гуравдугаар удаа хэлэхэд ах нь өгүүлрүүн: “Чи энэ үгийг юунд дахин дахин өгүүлнэ?”.

35. Бодончар өгүүлрүүн: “Тугаарын (саяын) Түнхэлэг горхиноо бүхий иргэнд эзэнгүй, их бага, сайн муу, толгой шийр цөм нэгэн адил чацуу байна. Ийм хялбар иргэн тул тэднийг бид эзэлж авъя”.

36. Ах нь өгүүлрүүн: “За тийм бол гэртээ хүрч, ах дүү нартай зөвлөлдөж, тэд иргэнийг эзэлье” гэж.

37. Гэртээ хүрээд, ах дүү нартай хэлэлцэж мордов. Тэргүүлэн хянагчид мөн Бодончарыг явуулав.

38. Бодончар тэргүүлэн явж нэгэн жирэмсэн эмийг барьж “Чи юун хүн бэ?” гэж асуувал, тэр эм өгүүлрүүн: “Би жарчиуд аданхан урианхайн хүн” гэв.

39. Тэндээс ах дүү тавуулаа тэд иргэнийг довтолж, адуу малыг авч, хүн ардыг зарц болгов.

40. Тэр жирэмсэн эм Бодончарт ирж хөвүүн төрөв. Түүнийг харь овгийн хөвүүн гэж Жажирадай гэж нэрийдэв. Жадараны өвөг тэр болов. Тэр Жажирадайн хөвүүн Тугудай нэрт бүлгээ. Тугудайн хөвүүн Бури-булчиру, Бури-булчиругийн хөвүүн Хар-хадаан бүлгээ. Хар-хадааны хөвүүн Жамуха бүлгээ. Жадаран овогтон тэд болов. (Жада гэдэг нь харь буусад гэсэн үг болно).

41. Тэр эм бас Бодончараас нэгэн хөвүүн төрүүлэв. Түүнийг барьж авсан эмийн хөвүүн хэмээн Баарьдай гэж нэрийдэв. Баарины өвөг тэр болов. Баарьдайн хөвүүн Зүтгэлбөх, Зүтгэлбөх олон эм авсан тул хөвүүн нь манан мэт (олон) төрөв. Манан баарин овогтон тэд болов.

42. Бэлгүнүтэй, бэлгүнүд овогтон болов. Бүгүнүтэй, бүгүнүд овогтон болов. Буха хатаги, хатагин овогтон болов. Бухату салжи, салжид овогтон болов. Бодончар, боржигин овогтон болов.

43. Бодончарын авааль эмээс төрсөн Барим ширату Хабич нэрт бүлгээ. Тэр Хабич баатрын эхийн инжид ирсэн эмийг Бодончар татвар эм болгон нэгэн хөвүүн төрсөнд Жаурьдай нэр өгөв. Бодончар амьд байх цагт Жаурьдайг зүхэл тайлгад орох эртэй болгов.

44. Бодончарыг үгүй болсны хойно тэр Жаурьдайг гэрт ямагт аданхан урианхайдай хүн байсан тул түүний хөвүүн гэж тайлгаас хөөж гаргав. Тэр Жэүрэдийн өвөг болов.

45. Хабич баатрын хөвүүн Мэнэн тудун бүлгээ. Мэнэн тудуны хөвүүн Хачи хүлүг, Хачин, Хачиу, Хачула, Харалдай, Хачиун, Начин баатар долоо бүлгээ.

46. Хачи хүлүгийн хөвүүн Хайду, Намулун эхээс төрсөн бүлгээ. Хачины хөвүүн Ноёгидай нэртэй бүлгээ. Ноён шиг авиртай тул ноёхон овогтон болов. Хачиугийн хөвүүн Баруладай нэрт бүлгээ. Их биетэй ба идээ барах ховдог тул Барулас овогтон болов. Хачулагийн хөвүүн бас идээ барах ховдог тул их барула, өчүүхэн барула гэдэг хоч нэртэй болж, улмаар эрдэмт барула, тодойн барула тэргүүтэн барулас овогтон болов. Харалдайн хөвүүн будаа мэт эх түрүүгүй хутгалдах тул будаад овогтон болов. Хачиуны хөвүүн Адархидай нэрт бүлгээ. Ах дүүгийн дунд адармаатай (яхир хэрүүлч) тул адархин овогтон болов. Начин баатрын хөвүүн Уруудай Мангудай хоёр бүлгээ. Урууд, мангуд овогтон болов. Начин баатрын авааль эмээс төрсөн хөвүүн Шижуудай Доголдай хоёр бүлгээ.

47. Хайдугийн хөвүүд Байшинхор догшин, Чирхай лянхуа, Чаужин ортагай гурав бүлгээ. Байшинхор догшны хөвүүн Тумбинай сэцэн бүлгээ. Чирхай лянхуагийн хөвүүн Сэнгүн билгэ, амбагайтан тайчууд овогтон болов. Чирхай лянхуа бэргэнээ эм болгон авч, нэгэн хөвүүн төржээ. Нэр нь Бэсүдэй гэнэ. Бэсүд овогтон болов. Чаужин Ортагай зургаан хөвүүнтэй нэр нь: Оронар, Хонхотан, Арулад, Сөнид, Хабтурхас, Гэнигэс гэдэг тул ийм овогтон болов.

48. Тумбинай сэцэний хөвүүн Хабул хаан Сэмсэчүлэ хоёр бүлгээ. Сэмсэчүлийн хөвүүн Бүлтэчү баатар бүлгээ. Хабул хаан, долоон хөвүүнтэй, тэдний нэр нь Охинбархаг, Бартан баатар, Хутугту Монхор, Хотала хаан, Хулан, Хадаан, Тодойн отчигин гэнэ.

49. Охинбархагийн хөвүүн Хутугту Жүрхи бүлгээ. Хутагту жүрхийн хөвүүн Сэчэ-бэхи Тайчу хоёр бүлгээ. Тэд жүрхи овогтон болов.

50. Бартан баатрын хөвүүд Мэнгитү хиан, Нэгүүн тайжи, Есүхэй баатар, Даридай отчигин энэ дөрөв бүлгээ. Хутугту Монхорын хөвүүн Бүри бөхө бүлгээ. Онон

мөрний шугуйд хуримлах цагт [Чингисийн дүү] Бэлгүтэйн мөрийг тэр тас цавчсан билээ.

51. Хотала хааны хөвүүд Зочи, Хирмау, Алтан гурав бүлгээ. Хулан Баатрын хөвүүн Их Чэрэн бүлгээ. [Их Чэрэнгийн боол] Бадай Хишлиг хоёр [Чингисийн үед] Дархадын ноёд болов. Хадаан Тодойн хоёр үргүй өнгөрчээ.

52. Хамаг Монголыг Хабул хаан захирч байв. Хабул хаан долоон хөвүүнээ байтал, Сэнгүн билгийн хөвүүн Амбагайг хамаг Монголын хаан болгохоор хэлсэн ажээ.

53. Буйр Хөлэн хоёр нуурыг холбож урсах Оршуун мөрөнд айргууд, буйргууд овгийн татаар аймаг нутаглана. Тэдэнд Амбагай хаан охиноо өгч, өөрөө охиныг хүргэж очоод татаарт баригдав. Татаар, Амбагай хааныг барьж, Хятадын Алтан хаанд хүргүүлэв.Бэсүд овгийн Балхачи гэдэг хүнийг элч болгож, Амбагай хааны хэлсэн нь: “Хабул хааны долоон хөвүүний дундахь Хоталад, миний арван хөвүүний дундах Хадаан тайжид чи очиж хэл. Хамгийн хаан, улсын эзэн байтал охиноо өөрөө үдэж хүргэхийг надаар цээрлэл болгогтун! Би татаар аймагт баригдав. Таван хурууны хумсыг тамтартал, арван хуруугаа барагдтал миний өшөөг авахыг оролдогтун” гэж илгээжээ.

54. Тэр цагт Есүхэй баатар, шувуу агнан явах зуур олхуноуд аймгаас эм аваад буцаж яваа мэргидийн их Чилэдү гэдэг хүнтэй уулзаж, түүний эмийг өнгийж үзвэл гоо үзэсгэлэнтэй хатан байна. Есүхэй баатар гэртээ давхиж ирээд ах Нэгүүн тайжи, дүү Даридай отчигин хоёрыг дагуулан мордож, их Чилэдүүг гүйцэж очвол.

55. Тэр айж хурдан ухаа морины гуяыг ташуурдаж, уулын бэлээр дутаав. Түүнийг гурвуулаа цувалдан хөөвөл тэр улам дутаасаар нэгэн хошууг тойрч эргэж тэргэндээ хүрч ирсэнд эм Өэлүн үжин (фүжин гэж хятадаар хатныг хэлнэ) өгүүлрүүн: “Тэр гурван хүний учрыг мэдэв үү чи? Тэдний царай сэжиглэмээр байна. Чиний аминд хор хүргэж болно. Амьд мэнд үлдвэл эхнэрийг олоход бэрхгүй. Мухлаг тутам охид бий. Тэрэг тутам хатад бий. [Миний мэт өнгөт эхнэр олдоно А.то.] Хэрэв намайг санавал дахин авсан гэргийг миний нэрээр нэрлэгтүн. Одоо амиа арчил. Миний үнэрийг үнэсэж яв” гээд өмссөн цамцаа тайлж өгөв. Их Чилэдү, тэр цамцыг морин дээрээс тонгойж авмагц, харвал, нөгөө гурав мөн хошууг тойрч нэхэж айсуй. Чилэдү, хурдан ухаа морины гуяыг ташуурдаж яаран Онон мөрөн өөд дутаав.

56. Түүнийг гурвуулаа хойноос нь нэхэж, долоон даваа давтал хөөж орхиод, Өэлүн үжинийг авч, Есүхэй баатар жолоодон хөтөлж, ах Нэгүүн тайжи тэргүүлж, дүү Даридай отчигин хажууд дагаж [тэмээг гилж А.то.] явна. Үүнд Өэлүн үжин өгүүлрүүн:
Миний эр Чилэдү,
Сэрүүн салхинд
Сэвлэг үсээ хийсгэж

Хээр хөдөө
Гэдсээ өлсгөж яахин зовох болов?
Одоо би хоёр сэвлэг үсээ хойш урагш унжуулж яахин одно?" гээд Онон мөрнийг долгилтол, ой шугуйг ганхтал их дуугаар уйлахад Даридай отчигин хажуунаас өгүүлрүүн:
Тэврэх хайрт эр чинь
Тэртээ даваг давав.
Уйлан санах эр чинь
Ус олныг гэтлэв.
Хайлж уйлавч
Харж чамайг үзэхгүй,
Хайж эрэвч
Хаалга зам нь олдохгүй.
[Гурван гол гэтэлгэв
Гурван гурви давуулав
Хайвал мөргүй
Харвал бараагүй
Хайлбал үл сонстоно. Ч.Ц.]
Дуугүй бай гэж ятгав. Өэлүн үжинийг Есүхэй баатар тэгээд гэртээ авчирч гэргий болгов. Өэлүн үжинийг Есүхэй баатрын авчирсан ёс ийм бүлгээ.

57. Амбагай хаан баригдаад Хадаан Хотала хоёрыг нэр заасан тул хамаг монгол, тайчууд нар Онон мөрний Хорхунагийн хөндий гэдэг газар цугларч хэлэлцээд, Хоталыг хаан болгов. Монголын жаргалан нь бүжиг, хурим бүлгээ. Хоталыг хаан өргөмжлөөд Хорхунагийн саглагар модны дор хавирга газрыг халцартал, өвдөг газрыг өлтөртөл дэвхцэн бүжиглэж хуримлав.

58. Хотала, хаан болоод Хадаан тайжитай хоёулаа татаар иргэнээс өшөө авахаар мордов. Татаарын Хотан бараг, Жали буха хоёртай арван гурван удаа байлдавч, Амбагай хааны өшөөг сайтар авч эс чадав.

59. Тэр цагт Есүхэй баатар, татаарын Тэмүжин-үгэ, Хори-буха зэргийн татаар хүнийг барьж ирэхэд жирэмсэн байсан Өэлүн үжин, Ононы Дэлүүн болдог гэдэг газар Чингис хааныг төрүүлжээ. Чингис төрөхдөө баруун гарт шагайн чинээ нөж атган төржээ. Татаарын Тэмүжин-үгээг барьж ирэх цагт тохиолдож төрөв гэж Тэмүжин нэрийг өгчээ.

60. Есүхэй баатрын Өэлүн үжинээс Тэмүжин, Хасар, Хачиун, Тэмүгэ дөрвөн хөвүүн төрөв. Бас Тэмүлүн нэртэй нэгэн охин төрөв. [Есүхэй баатрын нөгөө гэргий Сочигэл эхээс төрсөн Бэгтэр Бэлгүтэй хоёр бүлгээ. А.то.] Тэмүжинийг есөн настай байхад Зочи-Хасар долоон настай, Хачиун алчи таван настай, Тэмүгэ отчигин (отгон нь галын хаан, голомтын эзэн гэсэн үг болно) гурван настай, Тэмүлүн өлгийтэй байсан бүлгээ.

61. Есүхэй баатар, Тэмүжинийг есөн настай байхад Өэлүн эхийн төрхөм олхуноуд иргэнд хөвүүний нагац нараас охин гуйяа гэж Тэмүжинийг аваад одов. Явах замд Цэгцэр Чихургу гэдэг газрын хоорондХонгирадын Дэй сэцэнтэй уулзав.

62. Дэй сэцэн өгүүлрүүн: “Есүхэй худ аль хүрэхээр явна?” Есүхэй баатар өгүүлрүүн: “Миний хөвүүний нагац олхуноуд иргэнээс охин гуйхаар явж байна”. Дэй сэцэн өгүүлрүүн: “Энэ хөвүүн чинь нүдэндээ галтай, нүүрэндээ гэрэлтэй хөвүүн байна.

63. Есүхэй худ, би энэ шөнө, нэгэн зүүд зүүдлэв. Цагаан шонхор шувуу, нар сар хоёрыг атган нисэж ирээд миний гар дээр буув” гэж зүүдлэв. Нар сарыг бид нүдээр үздэг билээ. Гэтэл, нар сарыг шонхор шувуу атгаж миний гар дээр буух нь гайхалтай, ямар сайн тохиол учрах болов гэж би бусдад хэлсэн бүлгээ. Есүхэй худ чи, хөвүүн дагуулж ирсэн нь даруй миний зүүдний тайлбар болов. Юун зүүд байх вэ! Танай хиад аймгийн сүлд ирж, зүүдээр дохиолсон ажээ.

64. Манай хонгирад хэдийнээс бусдын нутаг ба хүнийг булаан тэмцэлддэггүй.
    Харь улсыг үл довтлон
    Хацар сайт охидоо
    Хасаг тэргэнд суулгаж
    Хар буур хөллөж
    Хатируулж одож
    Хаан болсон та нарын
    Хатан сууринд дэвшүүлж
    Хамт суулгана.
    Өөр иргэнийг үл тэмцэн
    Өнгө сайт охидоо
    Өлжгэтэй (суудалтай) тэргэнд суулгаж
    Өл буур хөллөж
    Үүсгэж одож
    Өндөр суурь эзлэгчдийн
    Өрөөл хань болгоно.
    Манай хонгирад хэдийнээс хацар гоо хатадтай, өнгө сайн охидтой тул зээгийн зүсээр, охидын өнгөөр явна.

65. Нуган хүүхэд нутгаа эзэмшинэ. Охин хүүхэд өнгө шилэгдэнэ. Есүхэй худ, миний гэрт оч. Надад өчүүхэн охин бий. Та үз” гэж, Дэй сэцэн хэлээд Есүхэйг гэртээ дагуулж аваачив.

66. Есүхэй худ, охиныг үзвэл нүүртээ гэрэлтэй, нүдэндээ галтай охин тул санаанд нийлэв. Түүний нэр Бөртэ гэнэ. Тэмүжинээс нэгэн нас ах, аравтай ажээ.Дэй сэцэний гэрт хоноод маргааш нь охиныг гуйвал, Дэй сэцэн өгүүлрүүн: “Олон удаа гуйлгаж өгвөл эрхэмлэгдэх, цөөн удаа гуйлгаж өгвөл доромжлогдох гэдэг боловч, охин хүний заяа, төрсөн үүдэнд өтлөхгүй тул охиноо өгье. Чи хөвүүнээ хүргэн болгож манай гэрт үлдээ” гэвэл, Есүхэй баатар өгүүлрүүн: “Би хөвүүнээ

орхиё. Миний хөвүүн нохойноос цочимтгой билээ. Эрхэм худ чи, миний хөвүүнийг нохойноос бүү цочуул!” гээд хөтөлж явсан мориор бэлэг өгч, Тэмүжинийг орхиод Есүхэй баатар буцав.

67. Есүхэй баатар, Цэгцэрийн шар талд явж байтал, татаар иргэн хуримлаж байхтай тохиолдоод ам цангах тул хуримд буув. Татаар нар Есүхэйг таньж, “Эрхэм Есүхэй ирэв” гэж хуримд суулгаад, урьдын булаагдсан өшөөг санаж, нууцаар хэлэлцэн, хоолонд хор хольж өгчээ. Есүхэй тэндээс мордож явах замд бие муужирч, гурван хоног арай гэж яваад гэрт хүрч.

68. Есүхэй өгүүлрүүн: “Миний дотор муу байна. Дэргэд минь хэн байна?” гэж асуувал, хонхотаны Чирха өвгөний хөвүүн Мэнлиг (Мэнлиг буюу Мунлиг) ойр байна гэвэл, түүнийг дуудаж өгүүлрүүн: “Хүү минь Мэнлиг чи сонс. Хөвүүн минь балчир билээ. Тэмүжин хөвүүнийг урагт орхиод ирэх замын зуур татаарт хорлогдов. Дотор минь муу байна. Өнчин хоцорсон дүү нараа, бэлбэсэн бэргэнээ асрахыг чи мэд. Тэмүжин хөвүүнийг даруй явж авчир! Хайрт Мэнлиг минь!” гээд наснаас нөгчив.

Үргэлжлэл бий...

To be continued...

Prepared by Dr. S. Erdenebulgan


Dr. T. Sukhbaatar

"МОНГОЛЫН АЛТАН ОРДНЫ УЛСЫН ЦЭРГИЙН ТҮҮХ" Энэхүү бүтээлийг эрхэм хүндэт дотно нөхөр, ангийн анд найз, түүхийн ухааны доктор, профессор, дэд хурандаа, Нирун овогт Ванчингийн Дашпунцаг (1978-2017) агсныхаа гэгээн дурсгалд зориулав.



Т.СҮХБААТАР

“МОНГОЛЫН АЛТАН ОРДНЫ УЛСЫН ЦЭРГИЙН ТҮҮХ”



Энэхүү бүтээлийг эрхэм хүндэт дотно нөхөр, ангийн анд найз, түүхийн ухааны доктор, профессор, дэд хурандаа, Нирун овогт Ванчингийн Дашпунцаг (1978-2017) агсныхаа гэгээн дурсгалд зориулав.

өмнөтгөл

Уншигч та бүхний өмнө түүхийн ухааны доктор Цэцэн Сартуул Шүлэгч Тогмидын Сүхбаатарын “Монголын Алтан ордны улсын цэргийн түүх” ном хэвлэгдэж очоод байна.

Энэхүү ном бол залуу судлаач Т.Сүхбаатарын хоёрдахь бүтээл бөгөөд Алтан ордны улсын түүхийн судалгаагаар Монголд хэвлэгдсэн хоёр дахь, Алтан ордны улсын цэргийн түүхээр гарч буй анхны бүтээл болно.

Монголын эзэнт гүрний баруун жигүүр болох түүхэнд Алтан ордны улс хэмээн алдаршсан Зүчийн улс нь евразийн орон зайд өөрийн нөлөөгөө тогтоон 300 жил оршин тогтнохдоо өөрийн гэсэн аугаа их соёлын ул мөрийг үлдээжээ. Өнөөгийн Оросын орны хүчирхэг нэгдмэл байх эх үндсийг Зүчийн улсын үед л бий болгосон гэдэгтэй судлаачид санал нэг байдаг.

Монголчуудын вассал байх үед л Орос үндэстэн нэгэн нэгдмэл улс болж төлөвшин, Зүчийн улсаас аж ахуй, соёл, эдийн засаг, засаг захиргаа, төрийн бүтэц зохион

байгуулалт, цэргийн урлаг, зэвсэглэл, цэргийн бүтэц зохион байгуулалт зэрэг маш зүйлсийг өвлөн авч өөрийн болгожээ.

Т.Сүхбаатарын Алтан ордны улсын цэргийн түүх бүтээл бол дан ганц цэрэг дайны түүхийг өгүүлээд зогсохгүй Зүчийн улсын үүсэл хөгжил, нэршил, засаг захиргааны зохион байгуулалт, төрийн бүтэц, аж ахуй соёл, шашин шүтлэг, соёл иргэншлийг бүгдийг судлан гаргасан анхны бүтээл болсон гэж үзэж байна.

Монголд Алтан ордны улсын түүхийн судалгаа өнөөдөр дөнгөж эхлэлийн шатандаа явж байна. Энэ талаар дагнан судалдаг судлаач гэвэл Т.Сүхбаатараас өөр хараахан үгүй байна. Т.Сүхбаатарын энэ бүтээл нь цаашид Алтан ордны улсын түүхийн судалгаанд томоохон хувь нэмэр оруулах бөгөөд шинжлэх ухаанд оруулж буй ач холбогдол нь ч нэн өндөр юм.

Цаашид энэ Алтан ордны улсын түүхээр дэлгэрэнгүй судалгаа явуулахаар залуу судлаач маань төлөвлөж байгаа бөгөөд тус улсын түүхийг аж ахуй, соёл иргэншил, шашин, худалдаа, эдийн засаг гэх зэргээр цуврал судалгааны бүтээл гаргаж байгаагийн эхлэл юм. Эдгээр нь Алтан ордны улсын түүхийн судалгааны нэгэн цуврал бүтээл болж нийтийн хүртээл болно.

Уг бүтээл нь докторын зэрэг хамгаалах ажлын хүрээнд бүтээгдсэн бөгөөд хамгаалуулах зөвлөлөөс тавьдаг шаардлагын дагуу хязгаарлагдмал хүрээнд бичигдсэн гэдгийг уншигч та бүхэн ойлгоно биз ээ.

Түүхийн ухааны доктор Ж.Базарсүрэн

МОНГОЛЫН АЛТАН ОРДНЫ УЛСЫН ТҮҮХИЙН СУДАЛГАА

Монголын эзэнт гүрний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох Зүчийн буюу “Алтан ордны улс” хэмээх улсын түүх олон орны эрдэмтэн судлаачдын анхаарлын төвд байж, эрдэм судлалын олон тооны бүтээл туурвигдсаар иржээ.

Монгол Улсад анх 1954 онд хэвлэгдсэн “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх”-ийн нэгэн ботид “Алтан ордны улс”-ын талаар цухас боловч дурдсан нь энэ сэдвээр манайд гарсан албан ёсны түүхийн эхлэл болсон бөгөөд 1966-1969 онд хэвлэгдсэн “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх”-ийн гурван ботийн III ангийн дөрөвдүгээр бүлэгт “Алтан ордны улс” гэсэн тусгай зүйл оруулж, тав, зургаадугаар бүлэгт уул сэдэвтэй холбоотой асуудлуудыг мөн товч тусгажээ. Гэвч тэр бүхэнд гагцхүү Марксист-Ленинист үзэл суртлын үүднээс хандсан, тухайн үед Алтан ордны улсын түүхийг тусгайлан судлах мэргэжлийн түүхчид дутмаг байсан зэрэг нь өнөөгийн өнцгөөс харахад учир дутагдалтай дүгнэлтүүдийг хийхэд хүргэжээ.

Монголын нийгэмд 1990-ээд оноос гарсан өөрчлөлт, ардчилсан хувьсгалын нөлөөгөөр түүх бичлэгт ч аливаа үзэл суртлаас ангид орших шинэ үе эхэлж, урьд өмнө

хязгаарлагдмал байсан сэдвүүдээр шинжилгээ, судалгааны ажил хийгдэх болж, олон тооны бүтээл, туурвил гарах болсон билээ.

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс (хуучнаар “Цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэн”) эртний монгол цэргийн түүхийн судалгааг 1950-иад оны сүүлч, 1960-аад оны эхнээс албан ёсоор эхлүүлж, 1996 онд “Монгол цэргийн түүхийн товчоон” хэмээх хоёр ботийг хэвлүүлжээ. Түүнд Зүчийн буюу “Алтан ордны” улсын цэргийн байгуулалтын тухай тусгайлсан бүлэг, зүйл байхгүй ч “Чингис хаан, түүний залгамжлагчдын аян дайн”-ыг бодитойгоор үнэлж цэгнэхдээ “Алтан ордны улс”-ын аян дайны талаар тусгай зүйлийг оруулсан нь шинэлэг зүйл байв.

“Төрт ёс, хаадын сан” төрийн бус байгууллагаас 1999-2000 онд “Монгол хаад” цуврал бүтээлүүдийг хэвлүүлсний дотор доктор С.Товуудорж “Зүчи хаан”, доктор Д.Цахилгаан, С.Лочин нар “Бат хан”, “Алтан ордны хаад” хэмээх хоёр бүлэг бүхий томоохон бүтээлийг туурвижээ. Гэхдээ эдгээр нь судалгааны зохиол гэхээсээ илүүтэй “Нийтлэл”-ийн хэлбэр давамгайлсан бүтээлүүд болжээ.

Монгол Улсын Шинжлэх ухааны академиас 2003 онд эрхлэн гаргасан “Монгол Улсын Түүх”-ийн таван ботид Алтан ордны улсын талаар урьд өмнөхөөс илүүтэй дэлгэрэнгүй тусгаж шинэчилсэн дүгнэлт хийжээ. Гэвч цэргийн түүхийн талаар бага тусгасан байна.

Доктор Ч.Чойсамба агсан 2003 онд “Бат хааны байлдан дагуулалт” хэмээх бүтээл хэвлүүлсэн бөгөөд тэр нь Бат хан гэж хэн байсан, түүний хийсэн аян дайнууд, тухайлбал Монгол, Орос цэрэг анх нүүр тулсан Калка голын байлдаанаас эхлээд Бат ханы удирдлагаар орос, европын олон хот цайзыг дайлсан аяны тухай өгүүлж, орос төвтэй үзлээс ангид, бодитой үнэлэлт, дүгнэлт хийхийг оролдсон, түүхийн судалгааны бус нийтлэлийн шинэлэг туурвил болсон байна.

Их Монгол Улсын 800 жилийн ойд зориулж ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс 2006 онд Монголын эзэнт гүрний түүхийн таван боть номыг хэвлүүлж гаргасны нэг нь доктор С.Цолмонгийн бичсэн “Монголын Алтан ордон улс” хэмээх нэгэн сэдэвт бүтээл байв. Уг бүтээл нь энэ сэдвээр туурвисан нэгэн сэдэвт анхдагч бүтээл болсон юм. Түүнд Бат ханы аян дайнаас эхлээд Алтан ордны улсаас эзэнт гүрний бусад улс болон Орос, гадаад орнуудтай харилцаж байсан түүх, эдийн засаг, худалдаа, зам харилцаа, хотуудын хөгжил болон Алтан ордны улсын мөхөл, түүнээс орос орны хөгжилд үзүүлсэн нөлөөллийн талаар тодорхой өгүүлж, Алтан ордны улсын түүхийн судалгааны хүрээн дэх “Орос төвтэй үзэл”-д шүүмжлэлтэй хандаж, шинжлэх ухааны үндэслэлтэй, бодитой дүгнэлт хийжээ. Мөн 2008 онд академич Ш.Бира Алтан ордны улсын соёлын тухай өгүүлэл бичиж нийтлүүлсэн байна.

БХЯ-ны Шинжлэх ухаан-технологийн зөвлөлийн захиалгаар 2010-2012 онд Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төв (судалгааны ажлын удирдагч Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн профессор, доктор (Sc.D) Х.Шагдар, гүйцэтгэгч Г.Ариунболд) “Алтан ордны цэрэг” сэдвээр судалгааны ажил гүйцэтгэсэн нь монгол цэргийн түүхийн салбар дахь энэ чиглэлийн судалгааны ажлын эхлэл болсон билээ. Түүнээс гадна профессор, доктор Х.Шагдар “Энэ дэлхийд эгнэшгүй

эцэг, хүү гурван жанжин: Сүбээдэй, Урианхадай, Ачу" бүтээлдээ кибчагийн тал, Булгар, Орос, Европт Сүбээдэй баатрын хийсэн аян дайны талаар өгүүлж үнэлэлт, дүгнэлт өгсөн байна. Мөн Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн профессор, доктор Ж.Базарсүрэн "Калка голын тулалдаан", "Мартагдсан ялалт буюу Ворскла голын тулалдаан", "Их Монгол Улсын цэргийн агсамж", "Кибчагчин аян хийгээд Легница-гийн тулалдааны учир холбогдлын тухайд" зэрэг Зүчийн (Алтан ордны) улсын цэрэг, дайны түүх, зэр зэвсэгтэй холбоотой сэдвээр судалгааны өгүүллүүд бичиж хэвлүүлжээ.

Профессор, доктор (Sc.D) Ш.Паламдорж өөрийн бүтээлдээ XIII зууны үеийн монгол цэргийн урлагийн үндэс, дайн байлдаанд бэлтгэх, байлдах арга ухаан болон байлдааны хангалтын асуудлыг стратеги, тактикийн түвшинд авч үзэж, өнөө үеийн цэргийн урлагийн үндсэн зарчмуудаар тэдгээрийн агуулгыг илэрхийлсэн байна.

Харин гадаадын олон судлаач Алтан ордны улсын түүхийг өөр өөрсдийн үзэл суртал, эрх ашгийн үүднээс судлан тайлбарласаар байгаа бөгөөд ялангуяа ОХУ-д энэ талаарх судалгаа эрчимтэй хийгдсээр байна.

Түүхэнд Чингис хааны гүйцэтгэсэн үүрэг болон Монголын эзэнт гүрний түүхийн болон Орос дахь Монголын нөлөөллийн тухайд бодитой үнэлэлт өгснөөрөө Н.М.Карамзин, Н.И.Костомаров, Н.А.Полевой, Н.Я.Данилевский, К.Н.Леонтьев, М.С.Грушевский нар онцгой ач холбогдол өгч байв. И.Н.Березин, В.В.Григорьев, М.И.Иванин, В.В.Бартольд, В.Я.Владимирцов нарын бүтээлүүд онцлог юм. Ийм байр суурийг "Евразийхан" хэмээх нэр авсан Оросын судлаач Н.С.Трубецкой, П.Н.Савицкий, Г.В.Вернадский, Эрэнжен Хара Даван нар үргэлжлүүлсэн бөгөөд тэд Орос улсын хөгжилд Монголын эзэнт гүрний үзүүлсэн дэвшилтэд нөлөөг онцгойлон тэмдэглэж ирсэн байна.

Харин Зөвлөлтийн Марксист-Ленинист түүхчид Европ төвт үзэл, Их Оросын шовинист үзлийн үүднээс Монголын эзэнт гүрний түүхийг судлах болсон бөгөөд Орос орны улс төрийн нэгдэл, эдийн засаг, соёл, хот байгуулалт, худалдаа, зам харилцаа, гар урлалын хөгжилд Алтан ордны улс ямар ч нөлөө үзүүлээгүй, монголчууд Орос орныг үгүйрүүлэн хоосруулж, Баруун Европын орнуудаас олон зуун жилээр хоцрогдуулсан хэмээх үзлийг баримтлах болсон билээ. Үүнд И.Н.Болтин, С.М.Соловьев, В.О.Ключевский, В.Т.Пашуто, М.И.Тихомиров, В.В.Каргалов, Л.В.Черепнинболон бусад олон түүхч хамаарна.

Гэвч тэр үед түүхийг үнэн зөв байдлаар харуулсан бүтээлүүд ч бас гарч байсныг үгүйсгэж болохгүй. Алтан ордны улсын түүхийн бодит судалгаанд Б.Д.Греков, А.Ю.Якубовский, А.Н.Насонов нарын бүтээлүүд чухал хувь нэмэр оруулсан юм. "Шинэ Евразийнхны урсгал"-ыг үндэслэгчийн нэгэн болох Л.Н.Гумилев Монголын эзэнт гүрний түүхийг бодитойгоор авч үзэж, түүхийг мушгин гуйвуулах явдлыг илчлэн няцаах оролдлого хийж байсан билээ.

1990-ээд оноос хойш Оросын зарим судлаач эх орныхоо түүхийн бүхий л үе, түүний дотор Оросын түүхэн дэх "Монголын үеийн" түүхийг аль болох бодитой авч үзэх талаар чармайх болсон нь ажиглагдаж байна. Үүнд, юуны өмнө Э.С.Кульпин, В.И.Пантин, В.В.Трепавлов, В.Л.Егоров, Ю.С.Худяков, Л.Ф.Недашковский, Ю.В.Кривошеев, Р.П.Храпачевский, А.Б.Широкорад, Ю.В.Мизун, Н.А.Макаров, А.Г.Юрченко, А. Доманин

зэрэг олон судлаачийн бүтээлийг дурдаж болно.

Алтан ордны улсын цэргийн түүх судлалаар ОХУ-д И.А.Воронцов, А.А.Сланов, И.М. Миргалеев, Г.Г.Хафизов, Ф.М.Ибятов, Е.И.Сусенков нар диссертац бичиж эрдмийн зэрэг хамгаалжээ.

Алтан ордны улсын түүхийн судлагдахууны хувьд авч үзвэл урьдын адил ихэвчлэн оросын сурвалж бичиг, археологийн эх хэрэглэгдэхүүнд тулгуурлаж байгаа боловч зарим эрдэмтэн европ, орос болон перс, араб, тэр ч байтугай монгол эх сурвалжийг өргөнөөр ашиглахыг хичээх болсон нь шинэ хандлага гэж болохоор байна.

Гэвч Алтан ордны улсын түүхийг гуйвуулж, орос төвт үзлийн үүднээс тайлбарлах оролдлого урьдын адил ихээхэн хүчтэй хэвээр байсаар байгаагаас гадна сүүлийн үед украин, казах, татаар төвт үзлийн үүднээс хандах үзэгдэл ч гарах болов.

Алтан ордны улсын түүхийн судалгааны нэгэн гол төв нь Татарстан болж, Казаны Их сургуульд Алтан ордны улсын түүхээр М.А.Усманов, М.З.Закиев нарын зэрэг судлаач дагнан ажиллаж байна. Гэхдээ татаарууд Алтан ордны улсыг өөрийн өвөг дээдсийн улс гэж үзэж, зарим нь Оросоос салан тусгаарлах үзлийн үндэс суурь болгохыг хүртэл оролдох болов. Тэгээд ч татаарууд бүр хожуу буюу XVIII сүүлч-XIX зууны эхэн үед гарч ирсэн (зохиосон) “Татаро-Монгольское иго” гэх нэр томьёог ашиглах хандлага сүүлийн үед давамгайлах болсон тул 2015 оноос ОХУ-д түүнийг өөрчлөн “Татар” гэх нэрийг нь хасч “Алтан ордны дарлал” (“Золото-Ордынское иго”) гэх нэр томьёог хэрэглэхээр албан ёсны шийдвэр гаргажээ.

Татаруудаас гадна Алтан Ордны улсын түүхийг казах, башкир зэрэг улс ч өмчлөхийг оролдсоор байна. Тухайлбал Казахстан улсын, Л.Н.Гумилевын нэрэмжит “Евразийн үндэсний их сургууль” голлох үүрэгтэй оролцож, судалгаа шинжилгээний ажлаа эрчимжүүлэн нэгэн сэдэвт бүтээлүүд хэвлэн гаргаж, эрдэм шинжилгээний хэд хэдэн хурлыг зохион байгуулж, илтгэл, өгүүллүүдийн эмхтгэл гаргаж нийтийн хүртээл болгож буй ажээ.

Гэхдээ ихэвчлэн түүхийн баримтуудыг казахын хэт даврууүндэсний үзлээр, өрөөсгөлөөр тайлбарлаж, Чингис хааныг казах үндэстэн гэхээр үл барам, одоогийн монголчуудыг Чингис хаантай огтхон ч хамаагүй, харин ч казахууд илүү ойр, удам угсаа нь гэх талын “судалгаа шинжилгээ” хийж сурталчилсаар байна.

Жишээ нь, Казахстаны түүхч Кайрат Закирьянов “Чингис хааны түрэг дууль” гэх номдоо тэр үед нүүдэлчин байсан бүх үндэстнийг монгол гэж нэрлэдэг байсан. Үгчилбэл, “Манкулам” гэж сонсогдох нь нүүдэлчин гэсэн утгатай гэж тайлбарлаж... Зөвхөн мөнх хөх тэнгэрийг шүтэж, өөр шашныг үгүйсгэсэн хойд ба зүүн зүгт нүүдэллэсэн хүмүүсийг манкулам гэж нэрлэдэг байсан...Тэд өнөөгийн Монголын нутаг дэвсгэрт амьдарч буй ард түмэн биш” гэсэн байх бөгөөд энэ мэт казахчилсан түүхийг казахстан даяар тархааж, улмаар түүнд нь гадаадынхнаар үл барам монголын казахууд ч итгэж эхэлж буйг интернетийн сайтуудад олноор тавигдсан зүйлүүд харуулж байна.

Бас Казакстаны судлаач А.Ш.Кадырбаев гэхэд Алтан ордны улс бол Монголынх биш, харин Түрэгийн улс хэмээн батлах оролдлого хийсэн байгаа нь дээрхтэй “агаар нэг” байна.

Алтан ордны улсын сэдвээр сүүлийн үед өрнөдийн түүхчид судалгаа шинжилгээ цөөнгүй хийж, нэгэн сэдэвт бүтээл олноор туурвих болов. Үүнд: С.Ж.Тарнбулын “Монголчууд”, Тимоти Мэй-ийн “Монголчуудын цэргийн урлаг”, Ричард А.Габриелийн “Чингис хааны цэргийн жанжин чин зоригт Сүбээдэй”, ХБНГУ-ын судлаач Б.Шпулерийн “Алтан ордны улс”, В.Хайссигийн удирдлагаар туурвисан “Монголчууд: түүх, соёл” хамтын бүтээл, Израилийн түүхч Рювен Амитай-Прейссийн “Монголчууд ба мамлюкууд: Мамлюк, Ил хаадын дайн. 1260-1281” болон Ж.Саундерс, Е.Филлипс, Л.Куонтен, Д.Флетчер, Ч.Галперин, Т.Олсен, П.Брент, Ж.Ведерфорд, Д.Морган, С.Эдшед нарын зэрэг олон судлаачийн ном бүтээл хэвлэгдэн гарсаар байна.

Гэвч дээр дурдсан бүтээлүүдэд Зүчийн (Алтан ордны) улсын цэргийн түүхийн талаарх судалгаа хангалтгүй туссан байгаа нь бидний зүгээс энэхүү судалгааг хийх нэгэн үндэслэл болсон юм. Бид энэ бүтээлдээ Зүчийн (Алтан ордны) улсын үүсэл хийгээд түүний нийгэм, эдийн засаг, улс төрийн тухай, мөн Алтан ордны улсаас гадаад улс оронтой харилцаж байсан харилцаа, цэргийн бүтэц зохион байгуулалт, цэргийн зэр зэвсэг, байлдах урлаг, байлдан дагуулалт хийгээд орос болон бусад улс оронд Алтан ордны улсаас үзүүлсэн нөлөөлөл зэрэг асуудлыг хамруулан авч үзлээ.

Гэвч энэхүү бүтээл нь докторын диссертацийн сонгож авсан сэдвийнхээ хүрээнд хязгаарлагдмал шинжтэй бичигдсэн бөгөөд цаашид Зүчийн (Алтан ордны) улсын түүхийг бүхэлд нь хамруулан судлах ажлын эхлэл төдий гэдгийг уншигч түмэн ойлгох буй за хэмээнэ.

Тэргүүн хэсэг

ЗҮЧИЙН (АЛТАН ОРДНЫ) УЛС

§ 1. ЗҮЧИЙН (АЛТАН ОРДНЫ) УЛС БАЙГУУЛАГДСАН ТҮҮХ

ливаа улс гүрний оршин тогтнохуйн гол нэг тулгуур багана нь цэрэг байдаг. Тухайн улсын цэрэг буюу зэвсэгт хүчин хэр хүчтэй байхаас түүний тусгаар тогтнол, аюулгүй байдал ихээхэн хамаардаг. Нөгөө талаар ямархуу зэвсэгт хүчинтэй байх нь улс гүрний удирдлагын баримталж буй цэрэг-улс төрийн бодлого, цэргийн номлолын шинж чанар, дэлхий дахины болон бүс нутгийн цэрэг-улс төрийн ерөнхий төлөв, тухайн цагийн байдал, үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, эдийн засгийн чадавх, нутаг дэвсгэрийн газар зүй, цаг уурын онцлог, хүн амын, түүний дотор цэргийн насныхны тоо, бодгалийн өвөрмөц шинж, амьдрал ахуйн хэвшлээс үүдэлтэй төрөлхийн авьяас чадвар, мөн түүнчлэн болзошгүй дайсан хийгээд дайн, байлдааны шинж чанар, тэр бүхэнтэй холбоотойгоор улс орны удирдлагаас боловсруулан хэрэгжүүлж буй цэрэг-улс төрийн бодлого зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлогдоно.

Мөн тухайн улс гүрэн олон улсын ямар эвсэл холбоонд хамаарагдаж буй болон бүс нутаг, хил залгаа улсуудын цэрэг-улс төрийн бодлого, чадвар чадавх ихээхэн хэмжээгээр нөлөөлдөг.

Цэргийн байгуулалтад улс гүрний цэргийн аж үйлдвэрийн салбарын чадавх, батлан хамгаалах салбарт хамаарах материалын болон хүний нөөц, түүний хуваарилалтын тогтолцоо ихээхэн нөлөөтэй. Мөн цэргийн эрдэм ухааны хөгжил, тээвэр холбоо, хүн амын цэргийн бэлтгэл, тэр ч байтугай тухайн үндэстэн, угсаатны төрөлх бодгалийн шинж чанар, чадавх, амьдрал ахуйн хэв шинж ч чухал нөлөө үзүүлдэг.

Зүчийн (Алтан ордны) улс, түүний цэргийн хувьд ч энэ бүх хүчин зүйл шууд нөлөөлж байсан нь дамжиггүй бөгөөд харин судлаачид өнөөг хүртэл энэ өнцгөөс харж шинжилгүй ирснээс түүнтэй холбоотой олон асуудал, түүний дотор улс байгуулагдсан он цагаас эхлээд цэргийн байгуулалтын онцлог, түүний дотор цэргийнх нь хүн хүчний тоо, зэр зэвсэг, цэргийн урлаг буюу стратеги, тактик, дайн байлдаан, ялалт, ялагдал зэрэг бараг бүхий л зүйлийг тодотгон тодорхойлох шаардлага тулгарч байна. Гэхдээ эл сэдвийг судалж тодорхойлох нь урт удаан хугацаа, нөр их хүчин чармайлт, олон хүний хүчин зүтгэл шаардах ажил бөгөөд эл бүтээл түүний эхлэл төдий гэдгийг хүлцэл өчин дурдах нь зүйтэй буй за.

Улс байгуулагдсан он цагийн тухайд. Евразийн өргөн уудам тал нутагт төвхнөсөн Зүчийн “Алтан ордны” улс” байгуулагдсан цаг хугацааг Оросын ихэнх судлаач 1242-1243 оноор авч үздэг. Гэвч зарим судлаачид Зүчи өөрийн улсыг бий болгох үндсийг 1224 оноос тавьсан, эсвэл Бат ханыг төр барьсан 1227 оноос, Бэрх ханыг төр барьсан цагаас эхлэн үзэх ёстой гэх мэтээр санал зөрөлдөх нь цөөн бус байдаг. Тэр ч бүү хэл ОХУ-ын Татарстан улс Алтан ордны улс байгуулагдсан цаг хугацааг 1269 оноор тооцон 2019 онд 750 жилийн ойг нь тэмдэглэхээр болж байна.

Оросуудын баримталж буй 1242-1243 оны үед Алтан ордны улс аль хэдийнээ байгуулагдчихсан байсан бөгөөд монголчууд Кибчагийг дайлж, өрнө зүг мордсон дайны хөлд орос орон өртөж, улмаар тэрхүү их аян дайн дууссаны дараа Оросын ялагдан дийлдсэн олон ноёдын (ванлиг) улсууд Алтан ордны улсын түшмэг улс болж алба барих болсон цаг үеэс эхлэн тооцож буй нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл тийм улс байдгийг оросууд мэдэрч эхэлсэн үеэсээ тооцож байгаа хэрэг юм. Мөн Татарстаны тооцож буй 1269 онд Алтан ордны улс байгуулагдаад улс болон төлөвшиж Мөнх-Төмөр хан төр барьж байсан цаг үе юм.

Сурвалж бичгүүдийн мэдээг харьцуулан үзэхэд Батыг Зүчийн буюу “Алтан ордны улсыг үндэслэн байгуулагч гэж үзэх нь учир дутагдалтай нь тодорхой байх агаад харин улсыг төвшитгөн засагч, залгамжлагч гэж үзэх нь үнэнд нийцнэ.

Судлаачид Алтан ордны улс байгуулагдсан, түүнчлэн энэ улсад Бат хан төр барьж эхэлсэн он цагийн тухайд хоорондоо зөрөөтэй хэд, хэдэн оныг санал болгодог. Үүнд, хамгийн эртнийх нь 1236 оныг дурдсан байх бөгөөд тэгэхдээ Бат хан Ижил мөрний Булгаруудыг байлдан дагуулсан үетэй холбож үзжээ. Мөн 1240 он буюу Киев хотыг эзлэн авсны дараа байгуулагдсан, эсвэл өрнийн дайнаас буцаж ирсэн 1242- 1243, оныг санал

болгодог. Гэхдээ дийлэнх олонх нь “Алтан ордны улс ”-ыг 1242 онд байгуулагдсан гэж үзсээр өнөөг хүрчээ. Энэ бүхэн нь Зүчи өөрт ногдсон газар нутаг дээрээ 1242 оноос өмнө нь улс гэрээ байгуулчихсан байсныг санаатай, санаандгүй ямар нэг хэлбэрээр үл тооцсон гэсэн үг. Харин Оросын түүхч М.Г.Сафаргалиев Алтан ордны улсын эх үүсвэр нь Зүчийн өөрийнх нь байлдан дагуулсан “ойн ард түмнүүд”-ын суудаг газар нутгийг Чингис хаан ууган хүүдээ захируулахаар хуваарилж өгсөн 1208 оны хавьд тавигдсан гэж тэмдэглэсэн байдаг.

